



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 266

Улаанбаатар хот

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед хадгаламж, зээлийн хоршоодод авч Хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.13, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 2.1.2, 2020 оны “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” 32 дугаар тогтоолын 2.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 145/124 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 1.3 дахь заалтын үйлчлэлийг Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан хугацаанд зогсоосугай.

2. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 145/124 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын зээлийн ангиллыг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл дор дурдсан байдлаар ангилж ажиллахыг нийт хадгаламж, зээлийн хоршооны гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Зээл	60 хоног хүртэл	61-120	121-210	211-360	361-ээс дээш

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН